



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 02

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 38,679,050 /гучин найман сая зургаан зуун далан есөн мянга тавь/ төгрөгийн балансын үнэтэй, 19,283,022.08 /арван есөн сая хоёр зуун наян гурван мянга хорин хоёр төгрөг найман мөнгө/-ний үлдэгдэл өртөгтэй цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон 6536 ДУА улсын дугаартай PATRIOT автомашины худалдах доод үнийг 7,000,000 /долоон сая/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар ( С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч ( Б.Оюунханд ) -д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга ( О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР

480219051